

Living the Lotus 4

Buddhism in Everyday Life

2026
VOL. 247



ОУХ-ийн дарга Маэда Бразил салбараар айлчилсан нь (2026.03.22)

Living the Lotus
Vol. 247 (2026.04)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, ОУХ
Хаяг: Fumon Media Center, 2-7-1
Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Нил цэцэг мэт эгэл даруухан

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Соосэки ба Шагжамүни бурхны шүлэг

Мэйжигийн 30-р он буюу 1897 онд зохиолч Нацүмэ Соосэки дотны найз Масаока Шикидээ “Нил цэцэг мэт эгэл даруухан амьдрахуй” хэмээх шүлгийг илгээсэн байдаг. Япон-Хятадын дайн (1894–95)-д ялалт байгуулсны дараа Япон улс орчин үеийн улс гүрэн болохоор ид баярлаж хөөрцгөлж байсан үе боловч энэ шүлэгт Соосэкигийн харуусах сэтгэл шингэсэн мэт санагдана.

Хүн өөрийгөө хувь хүн гэдгээр нь хүндэлж, өөрөөрөө бахархаж амьдрах мэдээж чухал. Гэхдээ үүнийг буруу ойлгох юм бол өөртөө хэт бардамнаж бусдыг дээрэлхэх онгироо сагсуу зан болон даамжирч, цаашлаад олны дунд дайн дажинг хүлээн зөвшөөрөх аюултай уур амьсгал бий болдог. Соосэки нийгмийн ийм бодит байдлыг хараад “Замын хажууд чимээгүйхэн ургах нил цэцэг мэт нүдэнд өртөхгүй ч хүчтэй амьдарч, харсан хүний сэтгэлийг тайвшруулах тийм л нэгэн болохсон” хэмээн бодож энэхүү шүлгээ тэрлэсэн болов уу.

4-р сарын 8-нд Шагжамүни бурхны төрсөн өдрийн баяр тохиодог ба тэрээр төрөөд удалгүй “Тэнгэр, газар дээр гагцхүү би эрхэм нандин” гэж хэлсэн гэх домог бий. Энэ үгний утгыг дахин бодоод үзвэл Соосэки лугаа адил төлөв даруу зан, өөрийгөө эргэцүүлэх сэтгэл хийгээд бусдыг үнэн сэтгэлээсээ хүндлэхийн чухлыг сургажээ.

Хүн бүр энэ орчлонд цор ганц байдаг нандин оршихуй. Үүнийг ухамсарлах юм бол онгироо сагсуу балмад зан гаргах, бусадтай сөргөлдөн тэмцэлдэх нь ямар олиггүй зүйл болохыг ойлгоно. Түүнчлэн өөрийгөө болон бусдыг хүндлэх буюу бүгдээрээ эв ээтэй амьдрах нь хүн болж мэндэлсний утга учир болохыг, цаашлаад “талархах, энэрэн нигүүлсэх сэтгэл хамгаас чухал” гэж сургадагийн учрыг илүү сайн ойлгох биз ээ.

Өөрөөр хэлбэл мундаг гайхамшигтай харагдаж зөвхөн өөртөө сэтгэл хангалуун амьдарснаас нүдэнд өртөхгүй эгэл жирийн ч гэлээ бусдын сэтгэлд амар амгаланг мэдрүүлж, эвтэй найртай амьдрах нь илүү аз жаргалтай гэсэн үг юм.



Хүн болж төрсний утга учир

Соосэки гуай өөрийгөө нил цэцэгтэй зүйрлэсэн бол та бүхэн ямар цэцэг байхыг хүсэж байна вэ?

Хаврын улирал болж байгаа болохоор хайр татам замбага, сакүра, багваахай цэцэгс эсвэл анхилуун үнэрт дафне цэцгийг нэрлэж болох юм. “Цэцэгсийн үзэсгэлэнг харьцуулах аргагүй” гэж хэлсэн байдаг шиг цэцэг бүхэн өөрийнхөөрөө хамаг сайхнаараа цэцэглэдэг тул аль нь гоё, аль нь илүү үзэсгэлэнтэй гэж хэлэх аргагүй.

Философич Нишида Китароо (1870–1945) гуай даруй “Цэцэг, цэцэг шиг байж гэмээнэ хамгийн үзэсгэлэнтэй. Хүн, хүн шиг байж гэмээнэ хамгийн гайхамшигтай.” гэж хэлсэн байдаг.

Бурхны сургаалыг сурч хэрэгжүүлдэг бид бүхний хувьд хүн шиг байна гэдэг нь хүний уг мөн чанар болох бурханлаг мөн чанараа ухамсарлаж, түүнийгээ амилуулж амьдрахыг хэлэх ба энэ нь чухамдаа жинхэнэ хүн шиг амьдрал юм. Бид хүн болж төрсний утга учир үүнд оршино.

Гэхдээ хүн хүний амьдралынхаа утга учрыг ойлгох цаг хугацаа харилцан адилгүй тул ялангуяа залуу хүмүүс яарч тэвдэж, сэтгэлээр унах шаардлагагүй.

Миний дуртай буддын шүлэг дотор нэг ийм шүлэг бий.

Хорвоо дэлхийд зүгээр л сайхан амьдар
Харин сайхан сэтгэлээ л байгаагаар нь түгээ (Сэккэй Сазэн)

Сэтгэлээ чөлөөлөн харуусал гуниг, уур бухимдлаа багасгаж, нүдэнд өртөхгүй ч гэлээ үргэлж хүний мөн чанарынхаа дагуу байгаагаараа бай гэсэн утгатай.

Санаа сэтгэл зовоох, уур бухимдал төрүүлэх өнөөгийн нийгэмд ийнхүү амьдарч, “эхлээд бусдын төлөө” гэсэн сэтгэлийг санаж, хүн бүр өөрийн онцлог бүхий цэцгийг дэлбээлүүлээрэй хэмээн хүсэж байна.

«Косей» сэтгүүл, 4-р сарын дугаараас



Чимээгүй дэлбээлэх нил цэцэг мэт

Маэда Такаши

Та бүхэн сайн байцгаана уу?

Энэ сар бол Шагжамүни бурхны мэндэлсэн сар. 4-р сарыг англиар “April” гэдэг ба латин “нээгдэх” гэсэн утгатай “аpегiге” гэдэг үгнээс гаралтай. Цэцэг дэлбээлж, амьдрал сэргэдэг хаврын улиралд Бурхан багш мэндэлсэн нь гүнзгий утга учиртай гэж би боддог.

Нивано ерөнхийлөгч энэ сарын айлдвартаа “нил цэцэг”-ийг нүдэнд өртөхөөргүй жижигхэн хэрнээ хүчтэй, хүний сэтгэлийг агшин зуурт тайтгаруулдаг гэж илэрхийлжээ. Өнөө үед үр өгөөж, үр дүнг чухалчлан улам л ахиж дэвших гэж яардаг болсон. Харин нил цэцэг бол өөрийгөө бусадтай үл харьцуулан, өөрийнхөө байх газраа цаг нь болохоор чимээгүйхэн цэцэглэдэг. Жижигхэн ч гэлээ салхинд үл ганхах бат бөх үндэстэй тул эрч хүчийг мэдрүүлнэ. Үүний нэгэн адил өдөр тутамдаа хэн нэгэнд чимээгүйхэн тусалдаг хүн үнэхээр гайхамшигтай биш гэж үү.

Шагжамүни бурхны төрөөд хэлсэн “Тэнгэр, газар дээр гагцхүү би эрхэм нандин” гэх үг нь зөвхөн өөрийгөө магтсан юм биш, хүн бүр ариун нандин оршихуй болохыг сургасан утгатай. Тийм ч учраас бид өөрсдийгөө бусадтай харьцуулалгүй, өөр өөрийнхөө байгаа газарт хичээнгүйлэн амьдрахад л болох юм.

Жижигхэн баяр баясал, учрал бүхнийг нандигнаж явбал бидний сэтгэл илүү хөгжиж сайжирдаг. Нивано ерөнхийлөгчийн айлдсанчлан, энэ сард нил цэцэг шиг өөрийнхөөрөө, онгирч бардамнахгүй, сөргөлдөж тэмцэлдэхгүй ураш алхацгаая. Ингэснээр бидний бурханлаг чанар чимээгүйхэн гэрэлтэж, улмаар эргэн тойрноо ч гэрэлтүүлнэ гэж бодож байна.




Их Ариун Ордонд илтгэл тавьсан Шри-Ланка салбарын гишүүн Дэлгода Сварна Падмини болон Олон улсын хэлтсийн ажилчдын хамт, 2026.03.12

Rissho Kosei-kai International


Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp